

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 - 6

1. *Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудал*

4 - 6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 12 дугаар сарын 26-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 57 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: С.Амарсайхан, О.Номинчимэг;
Чөлөөтэй: Э.Болормаа, С.Бямбацогт, Т.Доржханд, Л.Оюун-Эрдэнэ,
Н.Учрал, Л.Гантөмөр;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Э.Одбаяр.*

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдээр санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1. Засгийн газар 2024 оны 12 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 10

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Засгийн газар 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг 10 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
09 цаг 57 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя.

Дашзэвэгийн Амарбаясгалан, Батын Батбаатар, Баярмагнайн Баярбаатар, Сархадын Зулпхар, Лхагваагийн Мөнхбаатар, Нямтайширын Номтойбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Гончигдоржийн Уянгахишиг, Одонгийн Цогтгэрэл, Өлзийхүүгийн Шижир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 12 сарын 26-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай.

Нэг.Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2024 оны 12 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хоёр.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газар 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Гурав.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудлыг баталлаа. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

1.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Ингээд санал хураалт явуулна.

1.Засгийн газар 2024 оны 12 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

10 гишүүн буюу 76.9 хувиар санал дэмжигдлээ.

2.Засгийн газар 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Хуралдаанд оролцсон гишүүдийн 11 буюу 73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн буюу 73.3 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 05 минут үргэлжилж, 10 цаг 02 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД